



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 287

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй  
дуудлагын худалдаагаар худалдах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 3, 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Сургуулийн /"Тасис" хөтөлбөр/ үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 33,333,300.00 (гучин гурван сая гурван зуун гучин гурван мянга гурван зуун) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Монгол Улсын Их Сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгч Я.Төмөрбаатарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримт, худалдсан автомашиныг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолтын хамт 2020 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 12 дүгээр сарын 19-ны өдрийн  
287 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН /"ТАСИС" ХӨТӨЛБӨР/ ҮНДСЭН ХӨРӨНГӨД  
БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИН

| д/д | Автомашинны марк, улсын<br>дугаар, зориулалт,<br>хөдөлгүүр, арлын дугаар | Үйлдвэрлэсэн,<br>ашиглалтад<br>орсон он | Нийт<br>гүйлт /км/ | Балансын үнэ<br>/төгрөг/                                        | Хуримтлагдсан<br>элэгдэл<br>/төгрөг/ | Үлдэх<br>өртөг<br>/төгрөг/ | Сэргээн<br>босголтын<br>зардал<br>/төгрөг/ | Худалдах доод<br>үнэ /төгрөг/ |
|-----|--------------------------------------------------------------------------|-----------------------------------------|--------------------|-----------------------------------------------------------------|--------------------------------------|----------------------------|--------------------------------------------|-------------------------------|
| 1   | Ландровер дефендер улсын<br>дугаар 9652 УБХ арал-<br>САМАНМУ8УА138463    | 1995/1998                               | 370125             | 33,333,300.00                                                   | 33,333,300.00                        | -                          | -                                          | 1,500,000.00                  |
|     |                                                                          |                                         |                    | 33,333,300.00                                                   | 33,333,300.00                        |                            |                                            | 1,500,000.00                  |
|     | НИЙТ ДҮН                                                                 |                                         |                    | (гучин гурван сая гурван зуун<br>гучин гурван мянга гурван зуу) |                                      |                            |                                            | (нэг сая таван<br>зуу)        |